

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ
/эхний 11-р сарын байдлаар/

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 10.7 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 40.5 хувиар биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 1.5 тэрбум төгрөгөөр буюу 16.3 хувиар дээгүүр байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 7.9 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 0.1 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 47.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны жилийн эцсээс 12.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 21.4 тэрбум төгрөг болсон нь 2011 оны жилийн эцсээс 4.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Ургац хураалт, хадлан бэлтгэл: Төмс 64.51 га-д, хүнсний ногоо 23.67 га-д, тэжээлийн ургамал 42.3 га-д тариалалт хийж, төмс 683.2 тн, хүнсний ногоо 223.1 тн, тэжээлийн ургамал 99.8 тн-ыг тус тус хураан аваад байна. Энэ оны хураан авалт өнгөрсөн оноос төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Байгалийн хадлан 11.8 мян.тн, гар тэжээл 0.7 мян.тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс байгалийн хадлан 5.7 хувиар дээгүүр, гар тэжээл 6.1 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 29.1 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 3.8 тэрбум төгрөгөөр дээгүүр, оны үнээр 123.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 31.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, ул боов, зайрмаг, нүүрс, цайрын баяжмал, блок болон ихэнх төмөр эдлэлийн үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 11-р сард өмнөх 2011 оны жилийн эцсийнхээс 9.5 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана мах махан бүтээгдэхүүн 42.8 хувиар, жимс, жимсгэнэ 18.4 хувиар, мөн согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, хувцас, бөс бараа, гутал, боловсролын үйлчилгээ зэрэг бүлгүүдийн үнэ өссөн байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 11 сард 1155 эх амаржиж, 1166 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 566 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 13-аар буурсан байгаа бөгөөд вируст гепатит, цусан суулга, Бруцеллёз, тэмбүү, сүрьеэ, заг зэрэг өвчлөлүүд буурсан байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 809 болж урьд оны мөн үеэс 45 хүнээр хасагдсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 73.8 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 25.3 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай дунд, 39.3 хувь нь бүрэн дунд, 6.4 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 11 сард 1324 хүн шинээр бүртгүүлж, 1143 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 517 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 11 сард 231 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 40 хүн нас барж, 68 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 188.2 сая төгрөгийн хохирол учирсны 175.3 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 191 хүн холбогдон сэжиглэгдсэний 30.8 хувь нь согтуугаар, 9.9 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 2926 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 321 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 135 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

